



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/257

Чингис хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2-ын "а" "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/114 дүгээр захирамжийн 3 дахь заалтад нээлттэй дуудлагын худалдааг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 14:00 цагт Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай гэснийг нээлттэй дуудлагын худалдааг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 14:00 цагт Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай гэж өөрчилсүгэй.

2. Эд хөрөнгө худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Л.Батсайхэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ